



## НИЙСЛЭЛИЙН АГААР, ОРЧНЫ БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 02 сарын 16 өдөр

Дугаар А/23

Улаанбаатар хот

### Байгууллагын “2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-г батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 дэх заалт, Авлигын эсрэг хуулийн 2<sup>1</sup> дүгээр зүйлийн 2<sup>1.1</sup> дэх хэсэг, Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоол, газрын дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2023 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарласантай холбогдуулан байгууллагын “2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-г хавсралтаар баталсугай.

2. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг тухай бүрт холбогдох зардлаас санхүүжүүлж ажиллахыг Ахлах нягтлан бодогч Б.Байгалмаад зөвшөөрсүгэй.

3. Төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэн, тайлагнаж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (О.Алтангэрэл)-т үүрэг болгосугай.

ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ГАНБОЛД

1150500013



Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2023 оны 16-ны өдрийн дүгээр сарын 16-ны өдрийн дугаар тушаалын хавсралт

**НИЙСЛЭЛИЙН АГААР, ОРЧНЫ БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН 2023 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

| Д/д   | Хэрэгжүүлэх арга хэмжээ  | Хэрэгжих хугацаа | Байгууллагаас хэрэгжүүлэх арга хэмжээ   | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт   | Хөрөнгийн эх үүсвэр, зарцуулах мөнгөн дүн | Хариуцах нэгж, албан тушаалтан                                       |
|---|--|------------------|---|---|---|--|
| 1   | 2  | 3                | 4   | 5   | 6   | 7  |
| Зорилго 1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх |  |                  |   |   |   |  |
| 1   | 1.1. АТГ-аас бэлтгэсэн ТВ шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, цахим ном, гарын зурагт хуудас, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр иргэд, олон нийтэд хүргэсэн байх; | Жилдээ           | АТГ-аас бэлтгэсэн ТВ шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг байгууллагын албан ёсны вэбсайт, хамтран ажилладаг 4 вэбсайт, 2 телевизээр дамжуулан нийт давхардсан тоогоор 30,000,000 хүнд хүргэж ажиллана. | -Баримтжуулсан байх<br>-Үр дүнг тооцож, тайлагнасан байх;<br>(түгэсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо)<br>-Харьяа газар, нэгжүүдийг хамруулсан байх;  | Шаардахгүй                                | ЗСХ,<br>Сургалт, олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн |
| 2   | 1.2. Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, салбарын онцлогт тохируулан зохион байгуулах;   | Жилдээ           | Сар бүрийн сүүлийн 7 хоногт Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг байгууллагын албан хаагчдад "Танилцуулах хуудас"-аар танилцуулж, Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж ажиллана.  | -2-оос доошгүй өдөрлөг, нөлөөллийн ажиллагаа Г.М соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байх;<br>-Үр дүнг тооцож, нотломжийг хавсаргасан байх. | Шаардахгүй                                | ЗСХ,   |

|   |  |        |   |  |            |  |
|---|--|--------|---|--|------------|--|
| 3 | 1.3. Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбар ажиллуулах;   | Жилдээ | Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн /80:50 харьцаатай/ самбартай болж, мэдээ, мэдээллийг тухай бүрт шинэчилж ажиллана.     | -Мэдээллийг сар бүр шинэчлэх;<br>-Тайланд сар бүр шинэчилсэн нотломжийг хавсаргасан байх;  | 200,000    | ЗСХ,<br>Сургалт, олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн |
| 4 | 1.4. Өөрсдийн үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан 2 (шторк, зурагт хуудас, сонин) нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага, броюшур зэргээс боломжит хэлбэрийг сонгон) сурталчилгааг хийж олон нийтэд хүргэсэн байх; | Жилдээ | Өөрсдийн үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан 2 ширхэг сурталчилгааны материал боловсруулж иргэд, олон нийтийг уриалж ажиллана. | -2-оос доошгүй сурталчилгааны материал боловсруулсан байх;<br>-Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх;<br>-Авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулсан байх; | Шаардахгүй | ЗСХ,<br>Сургалт, олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн |

Зорилго 2. Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах

|   |  |            |   |   |            |                                      |
|---|--|------------|---|---|------------|--------------------------------------|
| 5 | 2.1. Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулсан байх;                | Жилдээ     | Авлигын эсрэг сургалтын санал, захиалгыг төлөвлөгөөнд тусгуулахаар саналаа АТГ-ын УССГХ- т хүргүүлсэн байх;             | -Шинэ томилогдсон албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад бүрэн хамруулсан байх;<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх; | Шаардахгүй | ЗСХ                                  |
| 6 | 2.2. Тухайн байгууллагын хариуцдаг, шууд хамаардаг, хамтран ажилладаг (тухайлбал, тусгай зөвшөөрөл эзэмшигч, | Улирал бүр | Байгууллагын агуулах, хангамжийн базуудад ажилладаг хяналт зохицуулалтын ажилтнуудаар дамжуулан АТГ-аас гаргасан тараах | -Өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулсан байх;<br>-Тайланд нотломжийг   | Шаардахгүй | ЗСХ,<br>БХХ-ын Хяналт, зохицуулалтын |

|  |   |                   |   |   |                   |  |
|--|---|-------------------|---|---|-------------------|--|
|  | <p>итгэмжлэгдсэн төлөөлөгч, хамтран ажилладаг бизнесийн байгууллага, үйлчилгээ авдаг хуулийн этгээд, иргэн, хяналт, оролцоо хэрэгжүүлдэг ТББ г.м) байгууллагад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх сурталчлах арга хэмжээг зохион байгуулах.</p> |                   | <p>материал бүхий зурагт зөвлөмжийг хамтран ажилладаг "Таван Толгой Тулш" ХХК, сайжруулсан шахмал түлшний тээврийн компаниудын ажилтан албан хаагчдад хүргүүлж ажиллана.</p>    | <p>хавсаргасан байх.</p>  |                   | <p>ажилтан</p>   |
| <p>Зорилго 3. Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох</p> |   |                   |   |   |                   |  |
| <p>7</p>   | <p>3.1. Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх;</p>   | <p>Тухай бүрт</p> | <p>Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгайлан нэг заалтаар тусган оруулна.</p>               | <p>-Байгуулсан бүх гэрээнд авлигаас ангид байх асуудлыг тусгасан байх;<br/>-Авлигыг мэдээлэх үүргийг тусгасан байх;<br/>-Гэрээг цуцалсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг оруулах;<br/>-Хэрэгжилтийн ач холбогдлыг үнэлж, дүгнэсэн байх;<br/>-Тайланд нотломжийг хавсаргасан байх;</p> | <p>Шаардахгүй</p> | <p>ЗСХ,<br/>Хүний нөөц, хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн,<br/>Хуулийн зөвлөх, гэрээ хариуцсан ажилтан</p> |
| <p>8</p>   | <p>3.2. "Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэх</p>  | <p>Жилдээ</p>     | <p>"Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ыг байгууллагын сайтын хууль эрх зүй цэсэд байршуулан сурталчлан ажиллана.</p> | <p>-Олон нийтийн хяналтад хамруулах чиглэлийг тодорхойлсон байх;<br/>-Сургалт, мэдээлэл авсан байх;<br/>-Хяналтын чиг үүргийг гүйцэтгүүлэх, тайлан зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлсэн байх.</p>  | <p>Шаардахгүй</p> | <p>ЗСХ,<br/>Сургалт, олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн</p>   |

| Зорилго 4. Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах |  |                        |  |  |            |   |
|---|--|------------------------|--|--|------------|---|
| 9   | 4.1. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх /Үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г. м/; | Жилдээ                 | Сар бүрийн сүүлийн 7 хоногт Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг байгууллагын албан хаагчдад "Танилцуулах хуудас"-аар танилцуулж, Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж ажиллана. | -Үйл ажиллагаанд эрсдэлийг тодорхойлж, урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг тооцсон байх;<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх; | Шаардахгүй | ЗСХ   |
| 10  | 4.2. Салбарын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах чиглэлээр хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, шалтгаан нөхцөлийг арилгасан байх;                                  | Хагас жил, жилийн эцэс | Салбарын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах чиглэлээр хэлэлцүүлэг, уулзалтыг 6 болон 12 сард зохион байгуулна.   | -2-оос доошгүйг зохион байгуулсан байх;<br>-Хэлэлцүүлэг, уулзалтын үр дүнд арга хэмжээ зохион байгуулсан байх;<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх         | 300,000    | ЗСХ   |
| 11  | 4.3. Үйлчлүүлэгчдээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулах.                                      | Жилдээ                 | Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбарт үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгаа авах хайрцаг байршуулж, саналыг нууц хэлбэрээр авна.                         | -Бодитой үр дүнг тооцсон байх;<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх   | Шаардахгүй | Архив, бичиг хэргийн эрхлэгч, Хяналт шинжилгээ, үнэлгээ, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн |
| Зорилго 5. Байгууллагын удирдлагын авлигатай тэмэх хүсэл эрмэлзлэл, санаачилга өрнүүлэх         |  |                        |  |  |            |   |
| 12  | 5.1. Удирдлагын зүгээс 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 1-р улиралд, хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд, хэрэгжилт, хүрсэн үр дүнг нийт албан хаагчдадаа танилцуулах;                      | 1 дүгээр улирал        | Удирдлагын зүгээс 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 1-р улиралд, хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд, хэрэгжилт, хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчдадаа танилцуулж ажиллана.         | -Танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан байх;<br>Албан хаагчдаас гаргасан санал санаачилгыг хэлэлцсэн байх;<br>-Арга хэмжээнд удирдлагын                   | Шаардахгүй | ЗСХ,<br>Хүний нөөц, хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн                                 |

|    |   |                 |  |   |  |
|----|---|-----------------|--|---|--|
| 13 | 5.2. Авлигатай тэмцэх газраас дүрэм журам, ёс зүйн дүрмийн төсөлд өгсөн санал, зөвлөмжийг тусгасан байдал;  | 1 дүгээр улирал | Авлигатай тэмцэх газраас гаргасан дүрэм журам, ёс зүйн дүрмийн төсөлд өгсөн санал, зөвлөмжийг байгууллагын "Авлигын эсрэг үйл ажиллагаа"-ны төлөвлөгөөндөө тусган ажиллана.  | -Тайланд нотломжийг хавсаргасан байх;   | ЗСХ,<br>Төлөвлөгөө гүйцэтгэл, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн |
| 14 | 5.3. Удирдлага салбар, нэгж, байгууллагын хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр санаачлан хийх ажил, арга хэмжээг нэмж төлөвлөн, тайлагнах;  | Жилдээ          | Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр нэг ажил санаачлан хэрэгжүүлж, "Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө"-г байгууллагын веб-сайтад байршуулж ажиллана.   | -Төлөвлөгөөг баталж, олон нийт танилцах боломжоор хангасан байх;<br>-khtulbulg.iaac.mn цахим санд нэмж оруулсан байх;<br>-Тайлагнасан байх; | ЗСХ,<br>Сургалт, олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн             |
| 15 | 5.4. Байгууллагын хэмжээнд мөрдөгдөж байгаа дүрэм, журам нь Нийслэлийн ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамж, Засгийн газрын тогтоолоор хүчин төгөлдөр бус төгөлдөр бус болсон эсэхэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх.         | Тухай бүрт      | Байгууллагын хэмжээнд мөрдөгдөж байгаа дүрэм, журам нь Нийслэлийн ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамж, Засгийн газрын тогтоолоор хүчин төгөлдөр бус болсон эсэхэд хяналт шинжилгээ, үнэлгээ тухай бүрт хийж ажиллана.                  | Хууль, тогтоомжийн хүчин төгөлдөр бус эсэхэд хяналт шинжилгээ, үнэлгээ тухай бүрт хийж ажилласан байх.                                      | ЗСХ,<br>Хяналт Шинжилгээ, үнэлгээ, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн        |
| 16 | 5.5. И-Монголиа, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүдээр үзүүлж байгаа төрийн үйлчилгээнээс бусад төрийн үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад хүнд суртал, чирэгдэлгүй үзүүлэх чиглэлээр ажил зохион байгуулах. | Жилдээ          | И-Монголиа, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүдээр үзүүлж байгаа төрийн үйлчилгээнээс бусад төрийн үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад хүнд суртал, чирэгдэлгүй үзүүлэх чиглэлээр нэгээс доошгүй ажлыг зохион байгуулна. | Байгууллагаас иргэдэд үзүүлэх үйлчилгээг хүнд суртал, чирэгдэлгүй үзүүлэх чиглэлээр 1-ээс доошгүй ажлыг зохион байгуулсан байх.             | ЗСХ, БХХ, АЧХЗБХ, ХШХ  |
| 17 | 5.6. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргаж байгаа өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, хугацаа хэтрүүлэхгүй байх, бодитой шийдвэрлэж хугацаанд нь зохих хариу өгөх.   | Жилдээ          | Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргаж байгаа өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, хугацаа хэтрүүлэхгүй байх, бодитой шийдвэрлэж хугацаанд нь зохих хариу өгөх.   | Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх хугацаа багассан байх.  | ЗСХ,<br>Архив, бичиг хэргийн эрхлэгч   |

|           |  |  |   |  |
|-----------|--|--|---|--|
|           | <p>нь зохих хариу өгөх ажлыг сайжруулах ажил зохион байгуулах. /Албан хаагчдын ёс зүйн зөрчил, дутагдал хамаарах/</p>  | <p>ажлыг сайжруулах ажил зохион байгуулан ажиллана.</p>  | <p>Хэн нэгэн албан тушаалтанд даалгасан тушаалын хэрэгжилт үр дүнг тооцох, тушаал шийдвэр гаргахдаа үндэслэх хэсэгт хамааралгүй хууль, тогтоол, захирамжийг үндэслэн тушаал гардаг асуудлыг арилгасан байх.</p> | <p>3СХ,<br/>Хүний нөөц, хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, Хуулийн зөвлөх, гэрээ хариуцсан ажилтан</p> |
| <p>18</p> | <p>5.7. Байгууллагын удирдлагаас гаргаж байгаа тушаал, шийдвэрийн үндэслэл, хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр ажил зохион байгуулж, хэлтэс нэгжийн дарга нарыг саналыг тусгахын зэрэгцээ, хуулийн үндэслэлийг зөв хэрэглэж ажиллана.</p>   | <p>Байгууллагын удирдлагаас гаргаж байгаа тушаал, шийдвэрийн үндэслэл, хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр ажил зохион байгуулж, хэлтэс нэгжийн дарга нарыг саналыг тусгахын зэрэгцээ, хуулийн үндэслэлийг зөв хэрэглэж ажиллана.</p>  | <p>Хэн нэгэн албан тушаалтанд даалгасан тушаалын хэрэгжилт үр дүнг тооцох, тушаал шийдвэр гаргахдаа үндэслэх хэсэгт хамааралгүй хууль, тогтоол, захирамжийг үндэслэн тушаал гардаг асуудлыг арилгасан байх.</p> | <p>3СХ,<br/>Хүний нөөц, хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, Хуулийн зөвлөх, гэрээ хариуцсан ажилтан</p> |
| <p>19</p> | <p>5.8. Худалдан авах ажиллагааг сайжруулах чиглэлээр тодорхой ажил зохион байгуулах.</p>  | <p>Байгууллагаас зохион байгуулж буй худалдан авах ажиллагааг сайжруулах чиглэлээр тодорхой ажил зохион байгуулна.</p>   | <p>Үнэлгээний хорооны гишүүдийг чадавжуулах, тогтмол оруулахаас зайлсхийх зэрэг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхад чиглэсэн ажил зохион байгуулах.</p>  | <p>Барилгын дулаан алдагдал, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн</p>  |
| <p>20</p> | <p>5.9. Байгууллагын төсөв, санхүүгийн сахилга, батыг сайжруулах чиглэлээр ажил зохион байгуулах. /2022 оноос хэрэгжиж эхэлсэн Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хуулиудыг хэрэгжүүлэх чиглэлээр ажил зохион байгуулах, мөн жил бүр Нийслэл, Үндэсний аудитын газраас төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус аудитын шалгалтаар жил бүр илэрдэг санхүүгийн зөрчил, дутагдлыг цаашид гаргахгүй байхад чиглэсэн үр дүнтэй ажил зохион байгуулах/</p> | <p>Байгууллагын төсөв, санхүүгийн сахилга, батыг сайжруулах чиглэлээр 2022 оноос хэрэгжиж эхэлсэн Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хуулиудыг хэрэгжүүлэх чиглэлээр ажил зохион байгуулах, мөн жил бүр Нийслэл, Үндэсний аудитын газраас төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус аудитын шалгалтаар жил бүр илэрдэг санхүүгийн зөрчил, дутагдлыг цаашид гаргахгүй байхад чиглэсэн үр дүнтэй ажил зохион байгуулан ажиллана.</p> | <p>Хууль тогтоомж болон жил бүр Нийслэл, Үндэсний аудитын газраас төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус аудитын шалгалтаар жил бүрийн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байх.</p>                                     | <p>3СХ,<br/>Ахлах нягтлан бодогч</p>   |